



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 12 сарын 29 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Г Халдварын сэргийлэлт хяналтыг Г
сайжруулах тухай

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга захирал нарт ДААЛГАХ нь:

Нэг. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, төлөвлөлт

1.1. Гамшгаас хамгаалах эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг цагийн байдал, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн тодотгол хийж, хэрэгжүүлэх;

1.2. Эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх хэсэг, оношилгооны хэсэг, амбулаторийн хэсэг, дэмжих үйлчилгээний хэсгийн тасаг нэгжийн үйл ажиллагааг эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгч хоорондоо уулзалдахгүй байхаар зохицуулах;

1.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж, тасаг, нэгжийн урсгалыг зөв тооцоолон, халдварын сэргийлэлт хяналтыг чанд мөрдөж, урьдчилан төлөвлөсөн төлөвлөлтийн дагуу сэлгэн, тусламж, үйлчилгээг үзүүлэх зохицуулалтыг хийх;

1.4. Үйлчлүүлэгчийн эмнэлэгт ирэх хөдөлгөөнийг бууруулж, байнгын хяналтад байдаг зорилтот бүлгийн иргэнд цахимаар зөвлөгөө өгөх, хяналт тавих, гэрээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх зохицуулалт хийх;

1.5. Эмчлэгч эмч болон коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтөнтэй ойрын хавьтал болсон эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь бусад мэргэжлийн эмчээс зөвлөгөө авах, эмч нарын хамтарсан үзлэг хийх шаардлагатай тохиолдолд аль болох цахимаар, утсаар холбогдож зөвлөгөө авах нөхцлийг бүрдүүлж, хэрэгжүүлэх;

1.6. Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх бол өвчтөнийг хүлээн авах лавлагаа төв, эмнэлэгтэй урьдчилан утсаар болон цахимаар холбогдох, нөхцөлийг бүрдүүлсний дараагаар шилжүүлэх;

1.7. Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, хүлээн авах болон бусад тасаг нэгжийг камержуулж, зөвлөгөө авах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх;

1.8. Эмнэлгийн улаан, шар, ногоон бүсийг тогтоохдоо үүсч болох нөхцөл байдал, ногоон бүст ажиллах эмч, мэргэжилтний тооцооллыг зөв тооцон, бэлтгэлийг хангах;

143200058

1.9. Халдвартай цогцостой харьцахад баримтлах зааврын дагуу хамгаалах хувцас хэрэгслийг цогцоор хэрэглэж, халдвараас хамгаалах дэглэмийг чанд баримтлах;

1.10. Тухайн эмнэлэгт коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан буюу сэжигтэй тохиолдол гарсан үед эмнэлэгт нас барсан хүний цогцосыг холбогдох шийдвэр гартал ар гэрт нь өгөхгүй байх;

1.11. Хэрэв эмчлүүлэгч PCR шинжилгээнд хамрагдаагүй байхдаа нас барсан бол цогцост коронавируст халдвар (КОВИД-19) илрүүлэх шинжилгээг хийх;

1.12. Хэрэв үйлчлүүлэгчид халдварын шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт ирэхгүй гэртээ байхыг зөвлөх, гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

1.13. Өвчтөний өрөөнд орох эмнэлгийн ажилтны тоог хязгаарлах, орсон гарсан хүн бүрийн бүртгэл хөтлөх,

1.14. Эргэлтийг хязгаарлах.

Хоёр. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх

2.1 Эрүүл мэндийн ажилтан тусгаарлагдсан тохиолдолд усанд орох, амрах нөхцөлийг бүрдүүлэх;

2.2 Эрүүл мэндийн ажилтнуудыг дархлаажуулах, амны хаалт, бээлий, хамгаалах хувцас хэрэгслээр тогтмол хангах, коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илрүүлэх PCR шинжилгээнд 14 хоногийн хугацаатайгаар тогтмол хамруулах;

2.3 Эмнэлгийн тасаг, нэгж, шаардлагатай өрөө бүрт гар угаах угаалтуураар хангах;

2.4 Эрүүл мэндийн ажилтныг тухайн эмнэлэгт халдвар гарсан үед сэлгэн ажиллуулах хүний нөөцийн төлөвлөлтийг хийж, албажуулан, албан тушаалтан бүрт танилцуулж, гарын үсэг зуруулж, дадлага сургуулилтад бүрэн хамруулах;

2.5 Эрүүл мэндийн ажилтны биеийн халууныг өглөө бүр хэмжих, ирцийн бүртгэлийг хянах, ирцийн бүртгэлээр ирээгүй хүний шалтгааныг тодруулах,

2.6 Эрүүл мэндийн ажилтанд халдварын эмнэлзүйн шинж тэмдгийн тандалт хийж, хүн тус бүрт тэмдэглэл хөтлөх,

2.7 Эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанг богино хугацаагаар ээлжлүүлэн ажиллуулах зохицуулалт хийх,

2.8 Эрүүл мэндийн ажилтнуудын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, дархлаа дэмжих ажлыг зохион байгуулах;

2.9 Халдварын эрсдэлийн тасаг, хэсэг болон эрүүл мэндийн ажилтны хамгаалах хувцас хэрэгслийн хангалтын тооцоог урьдчилан тооцох, өмсөх, тайлах сургалтыг тогтмол зохион байгуулж, хяналтын хуудсаар үнэлэх;

2.10 Эрүүл мэндийн ажилтнуудыг сэтгэлзүйн сургалтад хамруулж, зөвлөгөө өгөх;

2.11 Тухайн эмнэлэгт халдвар гарсан тохиолдолд эрүүл мэндийн ажилтнууд гэр бүлийн гишүүдтэйгээ харилцахад дэмжлэг үзүүлэх;

2.12 Тухайн эмнэлэгт халдвар гарсан тохиолдолд эрүүл мэндийн ажилтнуудад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, мэргэжлийн байгууллагын оролцоотой арга хэмжээг зохион байгуулах.

Гурав. Хүлээн авах ба яаралтай тусламжийн зохион байгуулалт.


3.1. Хүлээн авах дээр зөвхөн амьсгалын замын эмгэгийн хянах, хүлээн авах цэг гарган, коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдвараас хамгаалах дэглэм баримтлан ажиллах;

3.2. Амьсгалын замын халдвартай, сэжигтэй тохиолдлыг эмнэлгийн бусад тасаг, нэгжтэй холилдохгүй байхаар зохицуулалт хийх;

3.3. Хүлээн авах, яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгч бүрт амьсгалын замын эмгэгийн илрүүлэх, коронавируст халдвар (КОВИД-19)-ыг PCR шинжилгээ хийх;

3.4. Амбулатори, хэвтэн эмчлэх тасгаар үйлчлүүлж буй иргэн бүрээс амьсгалын замын болон коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдол байгаа эсэхийг тодруулсан асуумж авах;

3.5. Сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг яаралтай тусгаарлах, мэдээлэх, шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх.

САЙД  Т.МӨНХСАЙХАН